


САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД ИРГЭД, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС ИРҮҮЛЖ БҮЙ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын байгууллагууд болох үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын үйл ажиллагаатай холбоотой иргэд, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар нийт 319 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс салбар тус бүрээр ангилвал:

График 1




Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 141 өргөдөл, гомдол ирснээс хувьцаат компанийн үйл ажиллагаа, ногдол ашиг болон үнэт цаасны бүртгэлтэй холбоотой 44 өргөдөл, брокер, дилерийн компаниар эзэмшигчийн зөвшөөрөлгүй хувьцаа зарагдсан тухай 97 өргөдөл тус тус ирсэн байна.

Дээрх харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, хохирлыг барагдуулахаар мэргэжлийн оролцогч компаниудад 24,748,120.00 төгрөгийг төлүүлэх үүрэг өгснөөс 9,192,740.00 төгрөгийг төлүүлж, хоёр харилцагчийн 15,545,000.00 төгрөгийг төлүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Харин даатгалын салбарын хувьд нийт 140 өргөдөл, гомдол ирснээс жолоочийн хариуцлагын албан журмын, тээврийн хэрэгслийн, эрүүл мэндийн, ипотекийн цогц даатгал, тэтгэврийн даатгалын гэсэн төрлүүдээр нөхөн төлбөртэй холбоотой гомдол ирж байгаа бөгөөд нийт 168,490,778.00 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчдад олгуулж ажилласан байна.


Тайлант хугацаанд даатгалын бүтээгдэхүүний талаар ирүүлсэн өргөдөл гомдлыг төрлүүдээр ангилан харуулвал дараах байдалтай байна.

График 2



Тайлант хугацаанд бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 38 өргөдөл гомдол ирүүлснээс банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 17 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой 21 өргөдөл, гомдол ирсэн байна.

График 3



Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага тул иргэд, хуулийн этгээд, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдээс хувьцаат компанийн ногдол ашиг болон хувьцаа зөвшөөрөлгүй зарагдсан тухай, даатгалын компаниудын нөхөн төлбөр болон бичил санхүүгийн байгууллага тэдний үйл ажиллагаатай холбоотой ирсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хүрээнд хянан шийдвэрлэдэг болно.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТЭС**